**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО**
**НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН**
**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 09 сарын 30 өдөр Дугаар 3/37/26 Улаанбаатар хот

Гишүүдийн татварыг салбар холбоодод хуваарилах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 14 дугаар зүйлийн 14.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.4 дэх заалт, Гишүүн элсүүлэх, бүртгэх, гишүүнчлэлийг сунгах журмын 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн 2025 оны гишүүнчлэлийн татварыг салбар холбоодод хуваарилахдаа гишүүний төлсөн татварын оногдох хувийг тухайн гишүүдийн харьяалагдах салбар холбоодод энэхүү тогтоолын хавсралтад заасан дүнгээр хуваарилан олгохыг гүйцэтгэх захирал /М.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.
2. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн бүрэн эрхт салбар холбоодтой тооцоо нийлж, холбогдох санхүү бүртгэлийг зохих журмаар тайлагнан бүртгэхийг гүйцэтгэх захирал /М.Нарангэрэл/-д үүрэг болгосугай.
3. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” НЭЗХЭ-ийн гишүүнчлэлийн татварыг холбогдох хууль, мэргэжлийн нэгдсэн холбооны болон бусад дүрэм, журамд нийцүүлэн ил тод нээлттэй байдлаар зохион байгуулж, зарцуулалтыг 2026 оны ээлжит Нэгдсэн хуралдаанд тайлагнахыг салбар холбоодын тэргүүнүүдэд үүрэг болгосугай.

**ДАРГА О.МӨНХНАСАН**

"Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо" НЭЗХЭ-ийн
Удирдах зөвлөлийн 2026 оны 02 сарын 30-ны өдрийн
37 тоот тогтоолын хавсралт

| 2025 ОНЫ ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТ | | | |
|---|---|---|---|
| № | Салбар холбооны нэр | МТО-д төлсөн дүн (₮) | Буцаан олгох дүн (₮) |
| 1 | Жуулчин тээврийн салбар холбоо | 6,000,000 | 3,000,000 |
| 2 | АЖБХН (Багш) | 6,000,000 | 3,000,000 |
| 3 | Хөтөч-тайлбарлагчийн салбар холбоо | 6,000,000 | 3,000,000 |
| 4 | Хятадын зах зээлийн салбар холбоо | 67,800,000 | 19,650,000 |
| 5 | Европын зах зээлийн салбар холбоо | 56,400,000 | 19,500,000 |
| 6 | МОКТА | 63,900,000 | 28,200,000 |
| 7 | Дорноговь аймгийн салбар холбоо | 16,800,000 | 8,100,000 |
| 8 | Гадаад аяллын салбар холбоо (Outbound) | 45,600,000 | 8,500,000 |
| 9 | Жуулчны баазын салбар холбоо (ЖББХСХ) | 36,300,000 | 16,650,000 |
| 10 | АМТА | 43,200,000 | 15,100,000 |
| | **НИЙТ** | **348,000,000** | **124,700,000** |